

**“ДИЖИТАЛ КАТАЛИСТ” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2015 он 03 сарын 27 өдөр

Дугаар: 2015/02/01

Улаанбаатар хот

**ТАЙЛАН, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2015 оны 03 сарын 27-ний өдрийн тооллогын комиссын ..... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**  
*2015/01/02*

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс хуралд оруулж танилцуулсан тайланг баталсугай.
2. 2015 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн компанийн бизнес төлөвлөгөөг баталсугай.
3. Нэмэлт хувьцаа гаргах төсөлийг баталсугай.
4. Баталсан бизнес төлөвлөгөөг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн үр бүтээлтэй ажиллахыг компанийн Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГОМБО

**“ДИЖИТАЛ КАТАЛИСТ” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2015 он 03 сарын 27 өдөр

Дугаар: 2015/02/03

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн дугаар зүйл, 32-р зүйлийн 32.5, 42-р зүйлийн 42.4 дэх заалтууд, 2015 оны 03-р сарын 27-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

*2015/01/02*

1. “Дижитал Каталист” ХК компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх, хувьцааныхаа төвлөрлийг сааруулах зорилгоор нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50 000 000 ширхэг хүртэлх энгийн хувьцаа нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа нэмж гаргаж байгаатай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх Захиралд үүрэг болгосугай.
3. 50 000 000 ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гаргах шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГОМБО

**“ДИЖИТАЛ КАТАЛИСТ” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2015 он 03 сарын 27 өдөр

Дугаар: 2015/02/04

Улаанбаатар хот

**ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ  
ЭРХ ЭДЛҮҮЛЭХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.12 заалт, 38-р зүйл, 2015 оны 03-р сарын 27-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:** 2015/01/02

1. Компанийн нэмж гаргаж буй хувьцаанаас Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг одоогийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Санхүүгийн Зохицуулах Хороо нэмж хувьцаа гаргахыг зөвшөөрсөн тохиолдолд хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах журам, мэдэгдэлийг энгийн хувьцаа эзэмшигч бүрт хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг журмаар хүргүүлэхийг компанийн Гүйцэтгэх Захирал-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГОМБО

**“ДИЖИТАЛ КАТАЛИСТ” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2015 он 03 сар 27 өдөр

Дугаар: 2015/02/05

Улаанбаатар хот

**ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлүүд 2015 оны 03-р сарын 27-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:** *2015/07/02*

1. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож амжаагүй эсвэл хурлаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа хувьцаа эзэмшигчид Компаний тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэдгийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох шийвэрүүд гаран баталгаажсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
2. Хувьцаагаа эргүүлэн Компанид зарах хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг хууль тогтоомжийн дагуу хувьцаа эргүүлэн авах журмыг боловсруулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан ажиллахыг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөл энэхүү ажиллагаанд хяналт тавьж ажилласугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГОМБО

**“ДИЖИТАЛ КАТАЛИСТ” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2015 он 03 сарын 27 өдөр

Дугаар: 2015/02/02

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх заалт, 2015 оны 03-р сарын 27 –ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:** 2015/01/02

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хувьцааны төвлөрлийг сааруулах зорилгоор нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50 000 000 ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрсөн тул компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Компанийн оноосон нэрийг “Люкс зананду групп” ХК болгон өөрчилсүгэй.
3. Компанийн дүрэмд оруулж буй оноосон нэрийн болон хувьцааны тооны нэмэлт өөрчлөлт нь Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрлийн үндсэн дээр хийгдэхийг анхаарсугай.
4. Компанийн хувьцаа болон шинэчлэн баталж буй компанийн дүрмийг бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА *Г. Гомбо*



Г.ГОМБО



**“ДИЖИТАЛ КАТАЛИСТ” ХК**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2015 он 03 сар 27 өдөр

Дугаар: 2015/02/06

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн дугаар зүйл, 62-р зүйлийн 62.1.10, 62.1.11 дэх заалтууд, 2015 оны 03-р сарын 27-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

*2015/07/02*

1. Тус компани нь үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, гадны хөрөнгө оруулагчид болон дэлхийд алдартай мэдээлэл технологийн салбар, брэнд бүтээгдэхүүнийг монголд нэвтрүүлэх, үр ашигтай ажиллах, компанийн нэр хүнд, эдийн засгийн чадавхийг сайжруулах зорилгоор “Люкс зананду лимитед” компанийг өөртөө нэгтгэн худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. “Люкс зананду лимитед” компанийг үнэлсэн үнэлгээний тайланг зөвшөөрсүгэй.
3. “Люкс зананду лимитед” компанийг худалдан авч байгаатай холбогдуулан их хэмжээний болон нэгдмэл сонирхолтой талуудын хэлцэлийг батлахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд үүрэг болгосугай.
4. Худалдан авах төлбөрийг бэлэн мөнгөөр бус өрийг хувьцаагаар солих замаар хийхийг зөвшөөрсүгэй.
5. Өрийг хувьцаагаар солих төслийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГОМБО